

БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГУРВАНБУЛАГ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БУА-2021/35/СТА-ТШЗ

БУЛГАН АЙМАГ 2021 ОН

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд

**Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр**

Утас: 7034-2580 Цахим хаяг: [ankhbayard@audit.gov.mn](mailto:ankhbayard@audit.gov.mn)

**Аудитын менежер: Ж.Энхцоодол**

Утас: 7034-2716 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

**Ахлах аудитор: П.Содном**

Утас: 7034-2495 Цахим хаяг: [Sodnomp@audit.gov.mn](mailto:Sodnomp@audit.gov.mn)

**Аудитор: Г.Цэрэнлхам**

Утас: 7034-2495 Цахим хаяг: [Tserenkhamg@audit.gov.mn](mailto:Tserenkhamg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>АОУС</b>	Аудитын Олон Улсын Стандарт
<b>АО</b>	Ажил олгогч
<b>БСШУС</b>	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
<b>НБББББ</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
<b>ХХОАТ</b>	Хувь хүний орлогын албан татвар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>ХХК</b>	Хариуцлагатай хувьцаат компани
<b>НӨАТ</b>	Нэмэгдсэн өртгийн албан татвар

## **Агуулга**

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3.Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	16
4. Менежментийн захидал .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	15

## **1.Төрийн аудитын санал, дүгнэлт**

БУЛГАН АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ  
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Д.ТУНГАЛАГ ТАНАА

### **Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Гурванбулаг сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Аудитын гол асуудал**

Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэсэн, үндсэн хөрөнгө бараа материалын дансны ангиллыг буруу бүртгэсэн, зардлыг батлагдсан төсөв, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй зэрэг зөрчлүүд нь УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд, Сангийн сайдын 2014 оны 55, 2017 оны 347 дугаар тушаалтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, оршин байх, иж бүрэн байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>54,862,173.00</u></b>	<b><u>73,961,845.04</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	228,836.00	7,500,000.04
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	228,836.00	7,500,000.04
3351	Байгууллагаас авах авлага	-	7,500,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	228,836.00	0.04
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	54,633,337.00	66,461,845.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	35,556,371.00	-
35110	Тусгай зориулалттай материал	35,556,371.00	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	19,076,966.00	66,461,845.00
35410	Бичиг хэргийн материал	34,000.00	275,400.00
35420	Аж ахуйн материал	10,603,380.00	53,887,651.00
35440	Түлш, шатах тослох материал	5,032,500.00	599,500.00
35450	Барилгын засварын материал	1,553,400.00	1,642,900.00
35460	Хүнсний материал	1,418,186.00	7,601,494.00
35470	Бусад хангамжийн материал	435,500.00	2,454,900.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>196,659,757.35</u></b>	<b><u>195,934,568.13</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	196,659,757.35	195,934,568.13
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	181,257,757.35	179,182,568.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	167,205,437.98	167,205,437.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	(8,709,342.00)	(16,214,967.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,919,600.00	23,409,728.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,251,176.92)	(7,648,591.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,239,482.00	26,375,472.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,510,629.71)	(15,308,896.95)
39217	Ном	1,364,386.00	1,364,386.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	15,402,000.00	16,752,000.00
39301	Програм хангамж	-	1,350,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,402,000.00	15,402,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b><u>251,521,930.35</u></b>	<b><u>269,896,413.17</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>508,347.50</u></b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	508,347.50	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	508,347.50	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	508,347.50	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>251,013,582.85</u></b>	<b><u>269,896,413.17</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	251,013,582.85	269,896,413.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	42,154,984.00	42,154,984.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	84,232,178.95	103,115,009.27
51210	Өмнөх үеийн үр дүн	84,232,178.95	84,003,342.95

51220	Тайлант үеийн үр дүн	-	19,111,666.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,626,419.90	124,626,419.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>251,521,930.35</b>	<b>269,896,413.17</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>343,481,600.00</b>	<b>356,350,088.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>58,000,000.00</b>	<b>9,390,988.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	58,000,000.00	9,390,988.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	58,000,000.00	9,390,988.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	58,000,000.00	694,988.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө		8,696,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>285,481,600.00</b>	<b>346,959,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	269,049,600.00	331,022,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	269,049,600.00	331,022,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	16,432,000.00	15,936,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,432,000.00	15,936,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>277,288,447.59</b>	<b>337,238,421.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>277,288,447.59</b>	<b>337,238,421.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	271,574,729.27	277,984,207.92
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	181,092,681.18	195,597,697.70
210101	Үндсэн цалин	135,919,409.33	138,571,558.53
210102	Нэмэгдэл	22,353,264.00	37,350,847.17
210104	Урамшуулал	22,820,007.85	19,675,292.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,458,400.00	28,557,700.00
210201	Тэтгэврийн даатгал	15,951,700.00	16,909,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,876,700.00	4,902,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,501,300.00	1,798,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	375,300.00	1,190,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,753,400.00	3,756,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,715,903.32	18,816,461.00
210301	Гэрэл, цахилгаан	1,680,000.00	1,383,461.00
210302	Түлш, халаалт	10,913,003.32	17,433,000.00
210303	Цэвэр, бохир ус	122,900.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,370,220.00	4,679,060.00
210401	Бичиг хэрэг	39,100.00	206,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,139,720.00	1,155,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	426,000.00	225,000.00
210404	Ном, хэвлэл	6,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	43,500.00	326,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	715,900.00	2,765,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	39,857,189.00	17,349,012.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,600.00	54,700.00
210502	Хоол, хүнс	39,442,589.00	16,860,812.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	353,000.00	433,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,288,800.00</b>	<b>595,000.00</b>
210604	Урсгал засвар	1,288,800.00	595,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>97,700.00</b>	<b>56,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	97,700.00	56,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>100,000.00</b>	<b>366,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	366,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,593,835.77</b>	<b>11,967,277.22</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	246,920.00	100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,093,400.00	401,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,253,515.77	11,466,177.22
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,713,718.32</b>	<b>59,254,213.76</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>458,000.00</b>	<b>1,048,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	1,048,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	458,000.00	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,255,718.32</b>	<b>58,206,013.76</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,255,718.32	58,206,013.76
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>66,193,152.41</u></b>	<b><u>19,111,666.32</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>66,193,152.41</u></b>	<b><u>19,111,666.32</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>286,564,600.00</u></b>	<b><u>348,571,900.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>1,612,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	1,612,800.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	1,612,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,612,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>286,564,600.00</b>	<b>346,959,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	269,049,600.00	331,022,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	269,049,600.00	331,022,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	16,432,000.00	15,936,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,432,000.00	15,936,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,083,000.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,083,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>275,776,800.00</u></b>	<b><u>347,221,900.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>275,776,800.00</u></b>	<b><u>347,221,900.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>268,838,081.68</b>	<b>287,967,686.24</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	180,813,169.68	196,106,045.24

210101	Үндсэн цалин	135,411,061.83	138,571,558.53
210102	Нэмэгдэл	22,582,100.00	37,859,194.71
210104	Урамшуулал	22,820,007.85	19,675,292.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>23,458,400.00</b>	<b>28,557,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,951,700.00	19,563,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,876,700.00	2,248,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,501,300.00	1,798,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	375,300.00	1,190,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,753,400.00	3,756,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,264,452.00</b>	<b>14,383,461.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,680,000.00	1,383,461.00
210302	Түлш, халаалт	13,461,552.00	13,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	122,900.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,347,900.00</b>	<b>7,673,860.00</b>
210401	Бичиг хэрэг	95,100.00	450,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,017,500.00	1,155,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	426,000.00	225,000.00
210404	Ном, хэвлэл	14,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,241,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,794,900.00	3,601,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>36,546,660.00</b>	<b>25,273,120.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,600.00	54,700.00
210502	Хоол, хүнс	36,033,060.00	24,656,920.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	452,000.00	561,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,045,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,045,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>97,700.00</b>	<b>56,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	97,700.00	56,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>153,500.00</b>	<b>366,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	153,500.00	258,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	108,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,156,300.00</b>	<b>14,506,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,289,400.00	6,600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	866,900.00	7,906,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,938,718.32</b>	<b>59,254,213.76</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,683,000.00</b>	<b>1,048,200.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,083,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	1,048,200.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,255,718.32</b>	<b>58,206,013.76</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,255,718.32	58,206,013.76

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b>10,787,800.00</b>	<b>1,350,000.00</b>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<b>10,787,800.00</b>	<b>1,350,000.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<b>10,787,800.00</b>	<b>1,350,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	10,787,800.00	1,350,000.00
222001	Тоног төхөөрөмж	10,787,800.00	1,350,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b>(10,787,800.00)</b>	<b>(1,350,000.00)</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	42,154,984.00	124,626,419.90	84,232,178.95	251,013,582.85
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>42,154,984.00</b>	<b>124,626,419.90</b>	<b>84,232,178.95</b>	251,013,582.85
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>42,154,984.00</b>	<b>124,626,419.90</b>	<b>84,232,178.95</b>	251,013,582.85
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>42,154,984.00</b>	<b>124,626,419.90</b>	<b>84,232,178.95</b>	251,013,582.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(228,836.00)	(228,836.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>42,154,984.00</b>	<b>124,626,419.90</b>	<b>84,003,342.95</b>	250,784,746.85
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	19,111,666.32	19,111,666.32
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>42,154,984.00</b>	<b>124,626,419.90</b>	<b>103,115,009.27</b>	269,896,413.17

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	280,225,881.68	347,454,900.00	290,365,886.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	280,225,881.68	347,454,900.00	290,365,886.24

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	279,625,881.68	346,406,700.00	289,317,686.24
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	180,813,169.68	224,058,700.00	196,106,045.24
210101	Үндсэн цалин	135,411,061.83	154,784,000.00	138,571,558.53
210102	Нэмэгдэл	22,582,100.00	44,154,100.00	37,859,194.71
210104	Урамшуулал	22,820,007.85	25,120,600.00	19,675,292.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,458,400.00	28,557,700.00	28,557,700.00
210201	Тэтгэврийн даатгал	15,951,700.00	19,563,300.00	19,563,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,876,700.00	2,248,600.00	2,248,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,501,300.00	1,798,900.00	1,798,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	375,300.00	449,700.00	1,190,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,753,400.00	4,497,200.00	3,756,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,264,452.00	15,232,000.00	14,383,461.00
210301	Гэрэл, цахилгаан	1,680,000.00	2,080,000.00	1,383,461.00
210302	Түлш, халаалт	13,461,552.00	13,000,000.00	13,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	122,900.00	152,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,765,700.00	8,843,300.00	7,673,860.00
210401	Бичиг хэрэг	95,100.00	500,000.00	450,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,017,500.00	1,370,000.00	1,155,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	426,000.00	473,700.00	225,000.00
210404	Ном, хэвлэл	55,200.00	62,800.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,241,500.00	2,241,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,171,900.00	4,195,300.00	3,601,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	36,546,660.00	47,178,100.00	25,273,120.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,600.00	58,600.00	54,700.00
210502	Хоол, хүнс	36,033,060.00	46,558,000.00	24,656,920.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	452,000.00	561,500.00	561,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,490,000.00	1,200,000.00	1,045,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,490,000.00		
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,200,000.00	1,045,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	97,700.00	422,100.00	56,000.00
210702	Дотоод албан томилолт	97,700.00	422,100.00	56,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	153,500.00	2,303,800.00	1,716,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	153,500.00	845,800.00	258,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	108,000.00	108,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,350,000.00	1,350,000.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,036,300.00	18,611,000.00	14,506,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,289,400.00	8,111,400.00	6,600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,746,900.00	10,499,600.00	7,906,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	600,000.00	1,048,200.00	1,048,200.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	600,000.00	1,048,200.00	1,048,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	1,048,200.00	1,048,200.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	280,225,881.68	347,454,900.00	290,365,886.24
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	263,961,429.68	331,022,900.00	273,324,625.24
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	263,961,429.68	331,022,900.00	273,324,625.24
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	16,264,452.00	16,432,000.00	15,428,461.00
132001	Орон нутгийн төсвөөс	16,264,452.00	16,432,000.00	15,428,461.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	-	1,612,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	1,612,800.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	19.00	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	4.00	4.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	4.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	227.00	200.00	200.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	227.00	200.00	200.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	227.00	200.00	200.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>19.00</b>	<b>21.00</b>	<b>21.00</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	11.00	12.00	12.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	9.00	9.00

## **2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй байна.

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Гурванбулаг сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Д.Тунгалаг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, УСНББОУС-ын дагуу бараа материал, үндсэн хөрөнгийн тайлангийн дансны ангиллыг үнэн зөв бүртгээгүй, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зарчмыг хэрэгжүүлээгүй талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор Г.Цэрэнлхам хариуцаж гүйцэтгэв.

Гурванбулаг сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Бид аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Тус цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхийг зорин ажиллажээ. Мөн хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтыг зохион байгуулан ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.12 дахь заалт,
- Засгийн газрын “Хоолны зардлын дундаж норматив батлах” тухай 2019 оны 450 дугаар тогтоол,
- Засгийн газрын “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах” тухай 2020 оны 181 дүгээр тогтоол,
- Засгийн газрын “Цэцэрлэг сургуулийн үйл ажиллагааг түр зогсоох хугацаанд түр зогсоох хугацаанд үдийн хоол, үдийн цайн зардлаас хэмнэгдсэн хөрөнгийг Бямба гаригт ажиллах багш ажилтны цалин хөлс болон тухайн байгууллагын ариутгал халдваргүйжүүлэлтэд зарцуулах” тухай 2020 оны 64 дүгээр тогтоол,
- Засгийн газрын “Хүнсний дэмжлэг үзүүлэх” тухай 2020 оны 188 дугаар тогтоол,
- Засгийн газрын “Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 139 дүгээр тогтоол,
- БСШУС-ын “Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах” тухай 2020 оны А/224 дүгээр тушаал,

- БСШУС-ын “Заавар батлах тухай” 2020 оны 4/296 дугаар тушаал,
- БСШУС-ын “Төсөвт зохицуулалт хийх тухай” 2020 оны а/2788 тоот албан тоот
- БСШУС-ын “Зөвлөмж хүргүүлэх тухай хичээлийн сургалт түр хугацаагаар зогсоохтой холбоотой төсөв санхүүгийн харилцааг зохицуулах” тухай 2020 оны а/522 тоот албан тоот,
- БСШУС-ын “Зөвлөмж хүргүүлэх” тухай 2020 оны а/2018 тоот албан тоот,
- БСШУС-ын “Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах” тухай 2020 оны а/281 тоот албан тоот,

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Гурванбулаг сумын цэцэрлэг санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гурванбулаг сумын цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 337,238.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6,744.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өмнөх онд түүвэрт хамрагдан алдаа зөрчил материаллагаас их гарч байсан учир материаллаг байдлын түвшинг бууруулан 1 хувиар тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гурванбулаг сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,374.5 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	228.8	7,500.0	7,271.2
Бараа материал	54,633.3	66,461.8	11,828.5
Үндсэн хөрөнгө	196,659.8	195,934.5	(725.3)
Нийт хөрөнгө	251,521.9	269,896.4	18,374.5
Өр төлбөр	508.3	-	(50863)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	251,013.6	269,896.4	18,882.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	251,521.9	269,896.4	18,374.5

Төсөвт байгууллага нь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлдэг учир мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна. Оны эцэст цалингийн урьдчилгааны үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 7,500.0 мянган төгрөг болж 7,271.2 мянган төгрөгөөр өссөн нь Номин ногоон тал ХХК, Битачи ХХК хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 66,461.8 мянган төгрөг болж 11,828.5 мянган төгрөгөөр өссөн нь ковид-19 цар тахал халдварт өвчинтэй холбоотойгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоосонтойгоор бэлтгэсэн хөрөнгийг зарцуулаагүйгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 195,934.5 мянган төгрөг болж 725.3 мянган төгрөгөөр буурсан нь хандиваар эцэг эхчүүдээс тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, БСШУЯ-аас 2 ширхэг нөүтбүүк болон элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн дансны үнийг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор үүссэн хөрөнгөөр нэмэгдэж, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр үлдэх өртөггүй хөрөнгийг данснаас хассанаас тус тус шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 269,896.4 мянган төгрөг болж 18,882.8 мянган төгрөгөөр өссөн нь элэгдлээрээ өртгөө нөхөж дуусаагүй, үлдэх өртөгтэй хөрөнгийг данснаас хассан, тайлант оны элэгдлийн зардал болон үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Гурванбулаг сумын цэцэрлэгийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 763,608.2 мянга, орон нутгийн төсвөөс 21,435.0 мянга, нийт зарлагыг 785,043.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 437,588.3 мянган төгрөгөөр бууруулан, 347,454.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийн хоёр арга хэмжээг санхүүжүүлэх 331,022.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 16,432.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр төсвөөс 347,454.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 290,365.9 мянган төгрөгийг зарцуулан, 57,698.3 мянган төгрөгийг улсын төсөвт, 507.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт

/мянган төгрөг/				
Эдийн засгийн ангилал	Зардлын нэр	Батлагдсан	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	224,058.7	196,106.0	27,952.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал	28,557.7	28,557.7	-
2103	Байр ашиглалттай хол тогтмол зардал	15,232.0	14,383.5	848.5
2104	Хангамж, бараа материалын зардал	8,843.3	7,673.9	1,169.4
2105	Нормативт зардал	47,178.1	25,273.1	21,905.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200.0	1,045.0	155.0
2107	Томилголт, зочны зардал	422.1	56.0	366.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	2,303.8	1,716.0	587.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,611.0	14,506.5	4,104.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шаг урамшуулал	1,048.2	1,048.2	-

<b>ДҮН</b>	<b>347,454.9</b>	<b>290,365.9</b>	<b>57,089.0</b>
------------	------------------	------------------	-----------------

Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, АО-ийн нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэн нь дэлхий нийтээр тархаад байгаа Ковид-19 цар тахал гарч хол хорио тогтоосноор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаа зогссон, багш нарын илүү цаг, ур чадвар нэмэгдлийг олгоогүй зэргээс нөлөөлсөн байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй болно.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 1 мэдээлэл хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 32.0 сая төгрөгийн 8 зөрчилд, 0.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 31.2 сая төгрөгийн 3 албан шаардлага, 0.3 сая төгрөгийн 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт			Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь	/сая.төг/	
						Тоо	Дүн
Төлбөрийн акт	1	0.5	1	0.5	100.0	-	-
Албан шаардлага	3	31.2	3	31.2	100.0	-	-
Зөвлөмж	4	0.3	4	0.3	100.0	-	-
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>32.0</b>	<b>8</b>	<b>32.0</b>	100.0	-	-

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 40,050.5 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 22,101.2 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 17,949.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайланд 1,350.0 мянган төгрөгөөр СиТиЭйс 6.0 программ хангамжийг үндсэн хөрөнгөд орлогод аваагүй, мэдээлэл технологийн зардлаар тайлагнасан байсныг программ хангамж дансанд орлогодуулан залруулав.
2. УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаагүй тооцоолсон 12,055.2 мянган төгрөгийн нийт цалинг зардлыг цалингийн өглөг дансаар дамжуулаагүй, дансны давхар бичилт хийхгүйгээр шууд цалингийн зардалд бичсэн байна.
3. Хандиваар ирсэн 8,696.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшилыг 120017 дансанд салгаж тайлагнаагүй, 1200045 үнэ төлбөргүй орлого гэж тайлагнасныг залруулав.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 17,949.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд УСНББОУС-ын дагуу бараа материалын тайлангийн дансны ангиллыг үнэн зөв бүртгэж байгаа эсэх, мөн цар тахалтай холбоотойгоор тухайн байгууллагад очиж хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийгээгүй тул цаашид хөрөнгийн ашиглалтын хугацаа, хадгалалт, хамгаалалтын талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт:**

1.1. Илрүүлэлт: Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй 7,500.0 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэсэн байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл: Үргүй зардал гарч, өр авлага нэмэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах” заалтыг иөрдөж өр авлага үүсгэхгүй ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

#### **2. Зардлын данстай холбоотой асуудал:**

2.1 Илрүүлэлт: Ажил олгогчоос төлөх 2,897.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас бүлэг хооронд гүйлгэн шилжүүлэн зарцуулсан байна.

2.2 Эрсдэл: Зардлын гүйцэтгэл бодитой тайлагнагдахгүй байх.

2.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 55 дагуу тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулан бүлэг хооронд гүйлгэн шилжүүлэхгүй байх.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

### 3 *Балансын данстай холбоотой асуудал.*

3.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тайлангийн 39217 дансанд -4 тоо хэмжээтэй 49.2 мянган төгрөгийн багаж хэрэгслийн ачааны машин нэр бүхий номныг бүртгэсэн байна. 39201, 39205, 39207 дансны 7,502.8 мянган төгрөгийн нэр бүхий 30 хөрөнгө анхны өртгөөрөө элэгдэлээ бүрэн нөхсөн хөрөнгүүдийн үнийг дахин шинэчлэн тогтоогоогүй байна. Энэ нь тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2005 оны 233 дугаар тушаалаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 дүгээр тогтоолын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

3.2 Эрсдэл: Хөрөнгийн элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй, элэгдэл нь дууссан үндсэн хөрөнгийн их хэмжээний үлдэгдлийг актлаагүй байх.

3.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2005 оны 233 дугаар тушаалаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны өртөгөө нөхсөн хөрөнгийг ТӨБЗГ-ын 271 дүгээр тогтоолын 7-д хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай заалтыг мөрдөж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

Огноо: 2021/02/28

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

Огноо: 2021/02/28

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР

Г.ЦЭРЭНЛХАМ

Огноо: 2021/02/28

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.02.25</b>	Аудитын нэр: <b>Гурванбулаг сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>БУА-2021/35/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Гурванбулаг сумын цэцэрлэг</b>	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хандиваар авсан хөрөнгийг 1200017, 1200018 дансаар буюу бараа материал, үндсэн хөрөнгөөр салгаж бүртгээгүй.	8,696.0	1200045 дансанд нийлүүлж бүртгэлд тусгасныг салгаж тайлагнасан, залруулга хийсэн.	Эрхлэгч Нягтлан бодогч	Д.Тунгалаг, Н.Рэнцэнханд
2	Цалингийн зардлаас өглөгийн дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн.	12,055.2	Аудитын явцад залруулсан.	Эрхлэгч Нягтлан бодогч	Д.Тунгалаг, Н.Рэнцэнханд
3	Цалингийн зардлаас Ажил олгочийн нийгмийн даатгалын шимтгэлийг бүлэг хооронд шилжүүлэн төлсөн.	2,897.3	Тооцооны дансаар дамжуулж, стандартын дагуу НББ хөтөлж байх зөвлөмж өгөх	Эрхлэгч Нягтлан бодогч	Д.Тунгалаг, Н.Рэнцэнханд
4	Цэцэрлэгийн хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг зөрчин бараа бүтээгдэхүүнээ худалдагч тал хугацаандаа нийлүүлээгүй байна.	7,500.0	Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зарчмыг хэрэгжүүлээгүйд, Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүл ажиллах зөвлөмж өгөх	Эрхлэгч Нягтлан бодогч	Д.Тунгалаг, Н.Рэнцэнханд
5	39201, 39205, 39207 дансны үлдэгдэл элэгдлээ өртгөө бэрэн нөхсөн хөрөнгүүд байна. Сладанд элэгдэлийн зардал бодоогүй байна.	7,552.0	УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн стандартын дагуу зөв ангилж бүртгэх зөвлөмж өгөх	Эрхлэгч Нягтлан бодогч	Д.Тунгалаг, Н.Рэнцэнханд
6	Мөнгөн гүйлгээний тайланд 1,350.0 мянган төгрөгөөр СиТиЭйс 6.0 программ хангамжийн үндсэн хөрөнгөд орлогд аваагүй, мэдээлэл технологийн зардлаар тайлагнасан байсан.	1,350.0	Аудитын явцад залруулсан.	Эрхлэгч Нягтлан бодогч	Д.Тунгалаг, Н.Рэнцэнханд
<b>ДҮН</b>		<b>40,050.5</b>			